



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2012 оны 12 дугаар сар

Гадаад худалдааны эргэлт: \$11,123 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 11,123.5 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2%-иар буюу 193.3 сая ам.доллараар буурчээ. Үүнд импорт 239.6 сая ам.доллараар өссөн ч экспорт 432.9 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Жилийн өсөлтийн хурд өнгөрсөн оны мөн үеэс 85 нэгж хувиар буурсан бөгөөд үүнд импортын жилийн өсөлт 94 нэгж хувиар, экспортын жилийн өсөлт 75 нэгж хувиар буурсан нь нөлөөлжээ.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 53% буюу 5,854.7 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 17% буюу 1,928.1 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 8%-иар буурсан бол ОХУ-тай хийсэн худалдаа 12%-иар өсчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: -\$2,354 сая

Мөнгөн дүн 2012 оны эхний 12 сарын байдлаар 2,354.3 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 32%-иар буюу 573.4 сая ам.доллараар буурчээ. Энэ нь импорт 2%-иар өсч, экспорт 9%-иар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын шаталсан дунджаар (moving average) авч үзвэл 2012 оны 9 дүгээр сараас аажмаар багасч, хугацааны эцэст -8%-тай гарсан. Дүрслэл 1-ээс харахад экспорт, импортын жилийн өсөлтийн хурд 2011 оны 10 дугаар сараас хойш буурсан хэвээр байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: -\$1,519 сая

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшинд нөлөөлдөг суурь үзүүлэлт юм.

Энэхүү үзүүлэлт 2012 оны эхний 12 сард -1,518.7 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 3.6 дахин өсчээ. Үүнд валютын төлбөртэй импортын дүн экспортын дүнгээс 21.7 нэгж хувиар их буюу 13%-иар өссөн нь нөлөөлөв.


Гадаад худалдааны нөхцөл: 1.355

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс /2000 суурьтай/ тайлант хугацааны эцэст 1.355-д хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23%-иар буурлаа. Үүнд нефтийн бүтээгдэхүүний импортын үнийн өсөлт болон экспортын түүхий эдийн үнийн бууралт голлон нөлөөлжээ.


Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 12 сар			Өөрчлөлт			
	2012	2011	2010	2012/2011		2011/2010	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	11,123.5	11,316.8	6,177.1	(193.3)	-2%	5,139.7	83%
Экспорт	4,384.6	4,817.5	2,899.2	(432.9)	-9%	1,918.3	66%
Импорт	6,738.9	6,499.3	3,277.9	239.6	4%	3,221.4	98%
Тэнцэл	(2,354.3)	(1,681.8)	(378.7)	(672.5)	40%	(1,303.1)	5x


Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт



Бүтэц: 91%+ 9%

Нийт экспортод эзлэх ашигт малтмалын бүтээгдэхүүний хувь өмнөх оны мөн үеэс нэгж хувиар өсч 91% болов.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 90%, нийт экспортын 82%-ийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл өнгөрсөн оны мөн үеэс тус 4-н бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 0.7%-иар буурсан үзүүлэлттэй байгаа бол нийт экспортод эзлэх хувь 0.3%-иар өссөн байна.

Өсөлтийн хурд: -9%

Экспортын -9%-ийн жилийн өөрчлөлтийг бүтцээр нь задалж үзвэл ашигт малтмалын экспортын 7%, бусад экспортын 2%-ийн бууралтаар тайлбарлагдаж байна. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмалын экспорт 13%-иар буурсан нь уг бүлгийн бууралтын 3%-ийг, чулуун нүүрсний экспорт 17%-иар буурсан нь 9%-ийг бүрдүүлжээ. Харин төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн экспорт өнгөрсөн оны мөн үеэс өссөн нь нийт экспортын бууралтыг саармагжуулжээ.

Өөрчлөлт: 65%+35%

Экспортын дүн 432.9 сая ам.доллараар буурсны 65% буюу 281.4 сая ам.доллар нь тоо хэмжээний өөрчлөлтөөс, 35% буюу 151.5 сая ам.доллар нь үнийн дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспорт төмрийн хүдэр, боловсруулаагүй нефть, жоншны тоо хэмжээ болон үнийн дүн өссөнөөс шалтгаалж 181 сая ам.доллараар өссөн боловч нүүрс, цайрын хүдэр, зэсийн баяжмалын экспортын үнийн дүн, тоо хэмжээ зэрэг буурсанаас шалтгаалж, 524 сая ам.доллараар буурсанаас нийт ашигт малтмалын экспорт 339 сая ам.доллараар буурсан байна.

Ноос, ноолууран бүтээгдэхүүний хувьд ямааны угаасан ноолуурын экспорт нэмэгдсэн боловч самнасан ноолуурын экспорт буурсанаар уг бүлгийн экспорт өнгөрсөн оны мөн үеэс 1%-иар буурсан байна.

Бусад экспортын хувьд тоо хэмжээ, үнийн дүн зэрэг буурсанаас өмнөх жилийн мөн үеэс экспортын хэмжээ нь 98 сая ам.доллараар буурсан байна.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ


Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар унц тутамд 1,675.3 хүрсэнээр өнгөрсөн оны мөн үеэс 7.1%-иар өссөн бол өмнөх сараас 2.3%-иар буурсан байна. А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 7,907.0, 2,045.5 ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 4.2%, 12.2%-иар өссөн бол, өмнөх сараас зэс 0.9%—иар буурч, цайр 1%-иар өссөн байна.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2012			2011			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	%	Тоо/хэм (мян.тн,кг)	Дүн	%	Дүн	%	%2
1. Ашигт малтмал	3,982	91%		4,320	90%		(339)	-8%	-7.0%
Чулуун нүүрс	20,547	1,880	43%	21,144	2,262	47%	(382)	-17%	-9%
Зэсийн баяжмал	574	839	19%	576	969	20%	(130)	-13%	-3%
Төмрийн хүдэр/баяж.	6,416	533	12%	5,802	442	9%	91	21%	2%
Боловсруулаагүй нефть	3,568	336	8%	2,554	253	5%	83	33%	2%
Цайрын хүдэр ба баяж.	141	131	3%	121	143	3%	(12)	-9%	0%
Мөнгөжөөгүй алт	2,797	122	3%	2,581	110	2%	13	11%	0%
Жонш, лейцит, нефелинт	429	103	2%	407	95	2%	7	7%	0%
Молибдений хүдэр/баяж	4	38	1%	4	47	1%	(9)	-18%	0%
2. Ноос, ноолуур	193.2	4%		189.4	4%		4	2%	0.1%
Ямааны угааг ноолуур	3,608	15	3%	2,830	132	3%	13.5	10%	7%
Ямааны сам.ноолуур	533	48	1%	537	57	1%	(9.6)	-17%	-5%
3. Бусад	210	5%		308	6%		(98)	-32%	-2.0%
Нийт дүн	4,385			4,817			(432.9)	-9.0%	

%2 - Өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)


Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
		%		%		%
1. Ашигт малтмал	(226)	67%	(113)	33%	(339)	78%
Чулуун нүүрс	(256)	67%	(126)	33%	(382)	88%
Зэсийн баяжмал	(87)	67%	(43)	33%	(130)	30%
Төмрийн хүдэр ба баяжмал	47	51%	44	49%	91	-21%
Боловсруулаагүй нефть	63	76%	20	24%	83	-19%
Цайрын хүдэр ба баяжмал	(8)	66%	(4)	34%	(12)	3%
Мөнгөжөөгүй алт	9	73%	3	27%	13	-3%
Жонш, лейцит, нефелинт	5	67%	2	33%	7	-2%
Молибдений хүдэр ба баяжмал	1	-11%	(9)	111%	(9)	2%
2. Ноос, ноолуур	9	222%	(5)	-122%	4	-1%
Ямааны угаасан ноолуур	9.0	67%	4.4	33%	13.5	-3%
Ямааны самнасан ноолуур	(0.4)	5%	(9.2)	95%	(9.6)	2%
3. Бусад	(64)	65%	(34)	35%	(98)	23%
Нийт	(281.4)	65%	(151.5)	35%	(432.9)	

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнэ



Бүтэц: 27% + 21%

2012 оны эхний 12 сарын байдлаар нийт импортын 48%-ийг үйлдвэрлэлийн орц болон нефтийн бүтээгдэхүүн, 15%-ийг өргөн хэрэглээ, хүнсний бараа, үлдсэн 37%-ийг бусад төрлийн импортын бүтээгдэхүүн эзэлж байна.

Үйлдвэрлэлийн орц, нефтийн бүтээгдэхүүний импортын хувь өнгөрсөн оны мөн үеэс 1 нэгж хувиар буурсан нь дотроо нефтийн бүтээгдэхүүний хувийн жин 4 нэгж хувиар өсч, үйлдвэрлэлийн орцын хувийн жин 5 нэгж хувиар буурсантай холбоотой байна. Харин өргөн хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувийн жин өөрчлөлт багатай, тогтвортой хэвээр байна.

Өсөлтийн хурд: 4%

Импортын 4%-ийн өсөлтийг ерөнхий ангиллаар задалвал нефтийн бүтээгдэхүүний өсөлт +5%, өргөн хэрэглээ болон бусад бүтээгдэхүүний өсөлт +4%, үйлдвэрлэлийн орцын бууралт -4% байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 31%-иар буюу 328 сая ам.доллараар, өргөн хэрэглээний бараа 3%-иар буюу 25 сая ам.доллараар, бусад импорт 5%-иар буюу 118 сая ам.доллараар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Өөрчлөлт: +78% +22%

Импорт үнийн дүнгийн өсөлтөөс шалтгаалж 53.7 сая ам.доллараар, тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 185.9 сая ам.доллараар, нийтдээ 239.6 сая ам.доллараар өсчээ.

Нефтийн бүтээгдэхүүний импортын 328.3 сая ам.долларын өсөлтийн 63% буюу 205.6 сая ам.доллар нь тоо хэмжээний өсөлтөөс, 37% буюу 122.7 сая ам.доллар нь хилийн үнийн өсөлттэй холбоотой байна. Дүрслэл 6-с үзэхэд хилийн үнэ 2011 оны 5-р сараас эхлэн хурдацтай өсөөд, 2012 оны эхнээс буурах хандлага ажиглагдаж байсан боловч 8 сараас эхлэн буцаад өсөөд байна.

Өргөн хэрэглээний бүтээгдэхүүний өсөлтийн 80% нь тоо хэмжээний өсөлтөөс, 20% нь үнийн дүнгийн өсөлтөөс шалтгаалсан байна. Үйлдвэрлэлийн орцын импорт үнийн дүн 8 тоо хэмжээ зэрэг буурсанаас шалтгаалж 244.2 сая ам.доллараар буурчээ.

Зарим хэрэглээний барааны импорт*

Голлох хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст -22%-д хүрч буурсан байна. Үүнд суудлын автомашины жилийн өөрчлөлт 37% болж буурсан, цахилгаан барааны импорт 32%-иар буурсан нь голлон нөлөөлжээ.

Суудлын автомашины жилийн өсөлтийн хувьд 2010 оны эхэнд -61%-тай байсан бол 2011 оны эхэнд 318%-иар огцом өсч байсан боловч 2012 онд эргээд аажмаар буурсаар -37%-д буюу өмнөх жилийн мөн үеэс буурсан үзүүлэлтэд хүрээд байна.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	2012			2011			Өөрчлөлт			
	Тоо/хэм (тн,мян.ш)	Дүн	%	Тоо/хэм (тн,мян.ш)	Дүн	%	Дүн	Хувь	Хувь2	
Үйлдвэрлэлийн орц		1,817	27%		2,061	32%		(244)	-12%	-4%
Хүнд механизм, тоног төх.	12,542	1,113	61%	10,038	1,182	57%	105	15%	10%	
Суудлаас бусад автомашин	1,030	546	30%	944	733	36%	(187)	-25%	-9%	
Төмөр хийц, металл бүт.	35,056	55	3%	43,894	58	3%	(4)	-6%	0%	
Бусад бүтээгдэхүүн	581,791	104	6%	497,157	88	4%	16	18%	1%	
Нефть		1,394	21%		1,066	16%		328	31%	5%
Дизель түлш	716,483	820	59%	647,345	715	67%	105	15%	10%	
АИ-92, АИ-95	255,182	325	23%	199,718	223	21%	103	46%	10%	
А-80 болон бусад	192,149	249	18%	125,698	127	12%	121	95%	11%	
Өргөн хэрэглээ		798	12%		773	12%		25	3%	0%
Суудлын автомашин	46	430	54%	58	447	58%	(17)	-4%	-2%	
Цахилгаан бараа	1,067	155	19%	951	162	21%	(7)	-4%	-1%	
Бүх төрлийн эм	2,155	77	10%	3,421	53	7%	24	46%	3%	
Бусад өргөн хэрэглээний	17,564	136	17%	16,445	111	14%	25	23%	3%	
Хүнс		205	3%		192	3%		13	7%	0%
Гурил, будаа, талх	100,810	66	32%	103,295	60	31%	5	9%	3%	
Сүү, сүүн бүтээгдэхүүн	4,801	18	9%	3,638	14	7%	4	29%	2%	
Төрөл бүрийн өөх тос	25,168	33	16%	25,129	36	19%	(3)	-8%	-2%	
Согтууруулах ундаа	32,034	33	16%	25,198	25	13%	8	31%	4%	
Хүнсний ногоо	76,370	14	7%	82,860	16	8%	(2)	-14%	-1%	
Бусад	67,415	41	20%	60,653	41	21%	1	1%	0%	
Бусад импорт		2,526	37%		2,408	37%		118	5%	2%
Бусад		2,526			2,408			118	5%	5%
Нийт дүн		6,739			6,499			240	4%	4%

%2 - Өсөлтөд оруулсан хувь өмөр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ



Хүснэгт 5. Импортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн дүнгийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Эзлэх хувь	Эзлэх хувь	Эзлэх хувь	Эзлэх хувь	Эзлэх хувь	Эзлэх хувь
Үйлдвэрлэлийн орц	(113.4)	46%	(130.8)	54%	(244.2)	-102%
Хүнд механизм, тоног төх.	(43.7)	63%	(26.1)	37%	(69.8)	29%
Суудлаас бусад автомашин	(66.3)	36%	(120.4)	64%	(186.7)	76%
Төмөр хийц, металл бүт.	(8.6)	238%	5.0	-138%	(3.6)	1%
Бусад бүтээгдэхүүн	5.3	33%	10.7	67%	16.0	-7%
Нефть	205.6	63%	122.7	37%	328.3	137%
Дизель түлш	76.4	73%	28.1	27%	104.5	32%
АИ-92, АИ-95	61.8	60%	40.8	40%	102.6	31%
А-80 болон бусад	67.4	56%	53.8	44%	121.1	37%
Өргөн хэрэглээ	19.6	80%	5.0	20%	24.6	10%
Суудлын автомашин	(11.4)	65%	(6.1)	35%	(17.5)	-71%
Цахилгаан бараа	(8.1)	114%	1.0	-14%	(7.1)	-29%
Бүх төрлийн эм	11.8	49%	12.5	51%	24.3	99%
Бусад өргөн хэрэглээний	27.4	110%	(2.4)	-10%	24.9	101%
Хүнс	13.1	102%	(0.2)	-2%	12.9	5%
Гурил, будаа, талх	3.3	60%	2.2	40%	5.5	43%
Сүү, сүүн бүтээгдэхүүн	4.4	109%	(0.4)	-9%	4.1	32%
Төрөл бүрийн өөх тос	0.6	-20%	(3.6)	120%	(3.0)	-23%
Согтууруулах ундаа	5.6	71%	2.3	29%	7.9	61%
Хүнсний ногоо	(0.9)	44%	(1.2)	56%	(2.1)	-17%
Бусад	0.0	8%	0.5	92%	0.6	4%
Бусад импорт	61.0	52%	57.1	48%	118.0	49%
Бусад	61.0	52%	57.1	48%	118.0	100%
Нийт дүн	185.9	78%	53.7	22%	239.6	

Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж*



* Нийт импортын 70%-ийг бүрдүүлдэг 136 бүтээгдэхүүнээс өргөн хэрэглээний гэсэн 48 бүтээгдэхүүний хувьд тооцолов.